



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт,
үйлдвэрлэл, бизнесийн корпораци” төрийн өмчит
үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц,
албан тушаалын жагсаалт, орон тооны
дээд хязгаарыг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 370 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийн схемийг хоёрдугаар хавсралтаар, албан тушаалын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталж, орон тооны дээд хязгаарыг 25 байхаар тогтоосугай.

2.Дүрмийг улсын бүртгэлд зохих журмын дагуу бүртгүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Насанжаргалд даалгасугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

2020/05/05

000385

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**“ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУДАЛГАА, ТУРШИЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН КОРПОРАЦИ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” ТӨҮГ-ЫН (цаашид “үйлдвэрийн газар” гэх)-ийн үйл ажиллагааны чиглэл, удирдлага, бүтэц, хяналт, эд хөрөнгийн эрх, үүргийг тодорхойлох, өөрчлөн байгуулах, бүртгүүлэх, эрх зүйн байдал, санхүүжилттэй холбоотой нийтлэг харилцааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.2. Үйлдвэрийн газар нь малын гаралтай түүхий эдийг дэвшилтэт технологийн аргаар боловсруулах үндэсний технологийг бий болгох, шинжлэх ухаан, технологи, судалгаа, инноваци, туршилт, сургалт, аутсорсинг, зөвлөх үйлчилгээ, технологи нэвтрүүлэлт, эко-үйлдвэрлэл, итгэмжлэгдсэн лабораторийн үйлчилгээ, салбарын мэргэжилтэн бэлтгэх, дадлагажуулах, оюуны чадавхийг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийн инкубаци, үндэсний үйлдвэрлэл, экспортыг дэмжих чиг үүрэг бүхий өөрт олгогдсон хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх замаар ажиллаж иргэний гүйлгээнд ордог төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн.

1.3. Үйлдвэрийн газрыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан дагуу Засгийн газар байгуулах ба дүрэм, зохион байгуулалтын бүтэц, төсвийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар батална.

1.4. Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөнгөн үйлдвэрийн салбарын хууль, тогтоомж, төрөөс баримталж буй бодлого шийдвэр, чиглэлийн хүрээнд үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, арьс ширний салбарын тогтвортой хөгжлийг хангах, харилцан уялдааг бий болгох чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллана.

1.5. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаандaa Иргэний хууль, Үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Инновацийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, Хөдөлмөрийн хууль, Авлигын эсрэг хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

Хоёр. Үйлдвэрийн газрын оноосон нэр, хаяг

2.1. Үйлдвэрийн газрын оноосон нэр нь “Хөнгөн үйлдвэрийн судалгаа туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, товчилсон нэр нь ХҮСТҮБК, эсхүл “АРМОНО корпораци” ТӨҮГ байна.

- 2.2. Үйлдвэрийн газрын байршил нь байгууллагын удирдлага байрлаж буй, улсын бүртгэлд бүртгүүлсэн, Монгол улсад бүртгэлтэй хаягаар тодорхойлогдоно.
- 2.3. Үйлдвэрийн газрын оршин байгаа хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Арьс ширний үйлдвэрийн хашаа, "Хөнгөн үйлдвэрийн судалгаа туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци" ТӨҮГ-ын байр
- 2.4. Цахим холбоосууд: www.armonocorporation.mn, и-мэйл: armono_c@yahoo.com
- 2.5. Шуудангийн хаяг: Улаанбаатар 17032, Хан-Уул дүүрэг 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, "АРМОНО корпораци" ТӨҮГ-ын байр, 203 тоот
- 2.6. Утас: 70006002, 70006011, 70006004, 70006003

Гурав. Үйлдвэрийн газрын бэлгэдэл, тэмдэг

- 3.1. Үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгт, туг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкны харилцах данс, тамгатай байна.
- 3.2. Бэлгэдэл, барааны тэмдэгтийн загварыг захирлын тушаалаар баталж, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.
- 3.3. Үйлдвэрийн газрын тэмдгийг захидал, эсвэл захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.
- 3.2 Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагааны онцлог, уламжлалыг хадгалсан оноосон нэр, оюуны өмчөөр баталгаажсан барааны тэмдэгт ашиглаж болно.

Дөрөв . Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилго, үндсэн чиглэл

- 4.1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилго нь хөнгөн үйлдвэрийн салбарт био, нано, өндөр технологи болон инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, инкубацыг дэмжин хөгжүүлэх, шинэ технологийг дамжуулах, бойжуулах, салбарын бүтээгдэхүүнийг баталгаажуулан зах зээл дээр итгэлцлийг бий болгох, экспортыг дэмжих, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино.
- 4.2. Үйлдвэрийн газар нь хөнгөн үйлдвэрийн салбарт шинжлэх ухаан технологи, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажил, зөвлөх үйлчилгээ, үзүүлэх, сургалт, үйлдвэрлэл, инноваци, инкубаторын үйл ажиллагааг үр ашигтай явуулах, үйлдвэр технологийн парк болон инкубаторын дэд бүтцийг бүрдүүлэх чиглэлээр хүрээнд дараах технологийн болон үндсэн үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:

4.2.1. Шинжлэх ухаан, технологи, судалгаа, инновацийн чиглэлээр:

- 4.2.1.1. Арьс ширний салбарт төрөөс баримтлах бодлого, стратеги боловсруулахад мэргэжлийн байгууллагын зүгээс санал боловсруулж оролцох салбарын бодлогод нийцсэн, шаардлагатай асуудлаар шинжлэх ухаан, технологи, суурь судалгаа, инновацийн тесэл боловсруулах, хэрэгжүүлэх, судалгаа боловсруулалтын шинэ, дэвшилтэт арга, өндөр технологийг өөрийн орны онцлогт тохируулан судлах, нэвтрүүлэх;
- 4.2.1.2. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулах, дэвшилтэд техник технологийг дамжуулах, нэвтрүүлэх, бүх төрлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- 4.2.1.3 Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагааг цогцолбороор хөгжүүлэхэд идэвхтэй оролцох, тодорхой асуудлыг хариуцан ажиллах;

4.2.1.4 Хөнгөн үйлдвэрийн салбарт хөгжлийн загвар үйлдвэрийг цэвэр технологийн зарчимд нийцүүлэн ажиллуулах, салбарт шинэ технологийг нэвтрүүлэхэд манлайлан оролцох;

4.2.1.5. Салбарын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын оюутан сурагчдыг сургах, эрдэм шинжилгээ судалгааны ажилд дадлагажуулах ажлыг дэмжих;

4.2.1.6. Салбарын тулгамдсан асуудлаар эрдэм, шинжилгээний бага хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах

4.2.2. Инкубатор, бизнесийн үйл ажиллагааны чиглэлээр:

4.2.2.1. Хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бизнес инкубацийн үйл ажиллагааны хүрээнд хөнгөлттэй нөхцөлөөр үйлдвэр үйлчилгээний зориулалттай ажлын байраар хангах, бизнесийн зөвлөгөө өгөх, хөнгөлөлттэй зээлд хамрагдахад жуучлах, зах зээл олоход нь туслах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, интернетийн үйлчилгээ, аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах, гадаад дотоодын үзэсгэлэн яармагт жуучлах, бүтээгдэхүүнд нь лабораторийн шинжилгээ баталгаажуулалт хийх, зөвлөх инженерийн дүгнэлт гаргах өгөх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сантай холбоос тогтоох, хөрөнгө оруулалтын тооцоолол ТЭЗҮ хийх;

4.2.2.2. Инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гарааны компаниудын үйл ажиллагааг дэмжих;

4.2.2.3. Байнга нөхөн сэргэх боломжтой арьс шир, ноос ноолууран түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, боловсруулах, экологийн хувьд эзлтэй, экспортод чиглэсэн үндэсний брэнд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх судалгаа хийх;

4.2.3. Мэргэжлийн үйлчилгээний чиглэлээр:

4.2.3.1. Арьс ширний лабораторийг MNS ISO 170 25 : 2018 стандартын шаардлагад нийцүүлэн зохих журмын дагуу ажиллуулан дотоодын болон экспортын бүтээгдэхүүнд чанарын баталгаажуулалт хийх, удирдлага зохион байгуулалтын ажлыг эрхлэх;

4.2.3.2. Технологи, лабораторийн чиглэлээр хөнгөн үйлдвэрийн ажилтнуудыг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх сургалтыг явуулах;

4.2.3.3. Гадаад, дотоодын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх;

4.2.3.4. Арьс ширний салбарын стандарт, техник, болон технологийн баримт бичиг, ТЭЗҮ, төсөл, хөтөлбөр боловсруулах;

4.2.3.5. Арьс ширний салбарын техникийн номын сан, сургалт мэдээллийн төв ажиллуулах;

4.2.3.6. Арьс ширний салбарт техник, технологи, экологи, технологийн түвшин тогтоох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

4.2.3.7. Үйлдвэрлэл, инноваци, инкубатор, аж ахуйн үйл ажиллагаа явуулах;

- 4.2.3.8. Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд салбар дундын нээлттэй лаборатори ажиллуулах;
- 4.2.3.9. Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан сурагчдын дипломын дадлага болон үйлдвэрлэлийн дадлагын ажил удирдах, зөвлөгөө өгөх мэргэшүүлэх чиглэлээр дэмжиж ажиллах;
- 4.2.3.10. Хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг дунд үйлдвэрлэгчдийн инкубаторыг дэмжих сургалт, мэдээлэл, семинар, технологийн зөвлөгөө өгөх;
- 4.2.3.11. Хаягдалгүй цэвэр технологийн үйлчилгээний төв ажиллуулах;
- 4.2.3.12. Үйлдвэрийн газар нь үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэлд нийцсэн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

Тав. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх

- 5.1. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.2. Үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгийг данснаас хасах буюу борлуулах, устгах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.
- 5.3. Дангаар болон хамтран хэрэгжүүлсэн төсөлт хөтөлбөр, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон биет бус хөрөнгийг гэрээнд заасны дагуу эзэмшиж, захиран зарцуулж болно.
- 5.4. Үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн хөрөнгө, технологийн үйл ажиллагааны биет бус хөрөнгийг оюуны өмчийн тухай хууль, зохих хуулийн дагуу захиран зарцуулах, ашиглах, лицензийн гэрээгээр ашиглуулах, инкубаторын компаниудаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь эзэмшиж, болно.

Зургаа. Үйлдвэрийн газрын удирдлага, бүтэц

- 6.1. Үйлдвэрийн газар нь бүрэлдэхүүндээ дараах 4 үндсэн нэгжтэй байна. Үүнд:
 - 6.1.1.Захиргаа удирдлагын хэлтэс- хууль, хүний нөөцийн алба, санхүү хөрөнгө оруулалтын алба, инженер,техникийн алба, аж ахуй, үйлчилгээний алба;
 - 6.1.2.Шинжлэх ухаан, технологи-инновацийн төв-ар्पс шир материал, технологи судлалын алба- судалгаа туршилт инновацийн алба- байгаль орчны хяналт үнэлгээний алба;
 - 6.1.3.Арьс ширний төв лаборатори-түүхий эд, сорилт баталгаажуулалтын лаборатори- экологийн лаборатори, уураг нано-технологийг лаборатори, сургалтын микро лаборатори;
 - 6.1.4.Инкубатор, бизнес хөгжүүлэлтийн төв-маркетинг, зах зээлийн алба-технологи, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн алба-инкубаторын зөвлөх үйлчилгээний алба.
- 6.2. Үйлдвэрийн газар нь захирлын зөвлөл, эрдмийн зөвлөлтэй байна.

- 6.3. Захирлын зөвлөл нь үйлдвэрийн захиралд зөвлөх үүрэгтэй байгууллагын нэгж бүрээс төлөөлөл оролцсон бүрэлдэхүүнтэй байх бөгөөд захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг захирал батална.
- 6.4. Эрдмийн зөвлөл нь үйлдвэрийн газрын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлийг тодорхойлж, түүний явц, үр дүн болон эрдэм шинжилгээний бүтээлийн чанар, тувшинд үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй байна.
- 6.5. Үйлдвэрийн газрын өдөр тутмын ажлыг захирал удирдах бөгөөд захирлыг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар харьяа яамыг төлөөлсөн засгийн газрын гишүүнтэй зөвшилцэн томилж, чөлөөлнө.
- 6.6. Үйлдвэрийн газрын захирал нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай контракт байгуулан ажиллах бөгөөд гэрээний биелэлтийг бүрэн хариуцна.
- 6.7. Захирлыг томилоходо түүний эрдэм шинжилгээний ажлын дадлага, туршлага, мэргэжил, эрдмийн зэрэг, цолны байдал, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх мэдлэг, чадвар зэрэг шалгуураас зохих шатны байгууллагын тодорхойлолтыг гадна түүний харьяалагдах орон нутгийн татвар, цагдаа, шүүхийн байгууллагын тодорхойлолтыг харгалzan үзнэ.
- 6.8. Захирал нь үйлдвэрийн газрын технологийн болон үндсэн үйл ажиллагаа, судалгаа, эрдэм шинжилгээний ажил, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай контракт байгуулж ажиллана.
- 6.9 Контрактыг хуульд заасан хугацаанд дүгнэнэ.
- 6.10. Гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ хангалтгүй биелүүлсэн захирлыг үүрэгт ажлаас нь төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцэн чөлөөлнө.
- 6.11. Үйлдвэрийн газрын захирал нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд зохион байгуулна.
- 6.12. Захирал нь үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотойгоор, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар доор дурдсан эрх, үүрэлтэй байна:
- 6.12.1. Захирал нь контрактын хэрэгжилтийг ханган биелүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эрх мэдэлтэй байна.
- 6.12.2. Захирал нь итгэмжлэлгүйгээр байгууллагыг төлөөлөх эрхтэй бөгөөд энэ эрхийн хүрээнд дотоод гадаадын байгууллага, иргэдтэй харилцаж эрдэм шинжилгээ судалгааны ажлыг зохион байгуулах, технологи дамжуулах, үйлдвэрлэл худалдаа, хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах, хэрэгжилтийг хангах;
- 6.12.3. Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг баталж, албан тушаалтнууд, ажилтнууд, салбар нэгжийн удирдлагыг томилох, чөлөөлөх, сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх, шагнаж урамшуулах, шийтгэх асуудлыг шийдвэрлэх;
- 6.12.4. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд мөрдөх тушаал, зааврыг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж батлах ;
- 6.12.5. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд захиргааны бүтцийг батлах, албан тушаалын тодорхойлолтыг батлах, албан тушаалтныг томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, чөлөөлөх, цалин сангийн хэмжээнд тохируулан цалин тогтоох;

- 6.12.6. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох;
- 6.12.7 Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэл хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохиог байгуулах, тэдгээрийн үнэн зэвийг хариуцах;
- 6.12.8 Улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг тогтоох;
- 6.12.9 Маргаантай асуудлаар үйлдвэрийн газрыг төлөөлж шүүхэд нэхэмжлэх гаргах;
- 6.12.10 Хууль тогтоомжид заасан бусад эрх эдлэх;
- 6.14. Захирал нь дор дурдсан үүргийг хүлээнэ. Үнд:
- 6.14.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө үйлдвэрийн газрын үйл ажиллагааг бүрэн хариуцах, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 6.14.2. Үйлдвэрийн газрын технологи, үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг эрхэлж, төлөвлөгөөний биелэлтийг хангах, үйлдвэрийн газрын үйл ажиллагааг өргөжүүлэх, нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгох, нөөцийг бүрэн дайчлан санхүүгийн бие даасан байдлыг ханган ажиллах;
- 6.14.3. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр ашиг, чанарыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах, ашиг орлогыг хуваарилах асуудлыг шийдвэрлэх, биелэлтийг хангах;
- 6.14.4. Эрдэм шинжилгээ, технологи, туршилт судалгаа, үйлдвэрлэл, бизнесийн орчинд тогтвортой ажиллах бүтээлч хамт олныг бүрдүүлэх;
- 6.14.5. Ажиллагасдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- 6.14.6. Үйлдвэрийн газрын дотоод журам, хөдөлмөрийн хуулийн биелэлтэд хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулах;
- 6.14.7. Хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээ биелүүлэх;
- 6.14.8. Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, хууль гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захирлан зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашигласан бол хуулийн дагуу хариуцлага хүлээх;

Долоо. Үйлдвэрийн газрын санхүү, бүртгэл, тайлан, хяналт

- 7.1. Үйлдвэрийн газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.
- 7.2. Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, үндэсний аудитын газраас томилсон аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт болон зохих шатны байгууллагад хүргүүлнэ.
- 7.3. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.
- 7.4. Эд хөрөнгийн тооллогыг хагас жил, жилийн эцсээр явуулж баримтжуулна.

- 7.5. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.
- 7.6 Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна.
- 7.7. Үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө олж авах, данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 7.8. Үйлдвэрийн газар нь санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байх ба дотоод хяналт тавих журмыг захирал батална.
- 7.9. Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон холбогдох байгууллагаас хяналт тавьж ажиллана.

Найм. Үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтан

8.1. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх хэсэгт заасан албан тушаалтныг үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтанд тооцно. Үйлдвэрийн газрын захирал, хэлтэс, албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ТАЦ хариуцсан нягтлан бодогч лабораторийн эрхлэгч зэрэг албан тушаал эрхэлдэг этгээд нь эрх бүхий албан тушаалтан байна.

8.2. Эрх бүхий албан тушаалтан нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хashiж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж өгөх үүрэгтэй. Эрх бүхий албан тушаалтан нь энэхүү дүрэм, үр дүнгийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргийг биелүүлж, үйлдвэрийн газрын ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

8.3. Эрх бүхий албан тушаалтан нь санаатайгаар хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас үйлдвэрийн газарт хохирол учирсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

8.4. Эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хэм хэмжээг холбогдох хууль тогтоомж, үр дүнгийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно.

Ес. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны санхүүжилт, үйл ажиллагааны тайлан

9.1. Үйлдвэрийн газрын тухайн жилийн орлого нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ. Үүнд:

- 9.1.1. Улсын захиалгатай суурь судалгаа, шинжлэх ухаан, технологи, инноваци, технологийн зүгшрүүлэлтийн төслийг шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр;
- 9.1.2. Орон нутгийн захиалгатай эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр;
- 9.1.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлыг захиалагчийн хөрөнгөөр;

- 9.1.4. Салбарын стратегийн чиг хандлагад тусгагдсан захиалгатай суурь судалгаа, шинжлэх ухаан, технологийн төслийг өөрийн болон хандивын хөрөнгөөр;
 - 9.1.5. Улсын төсвийн олгох санхүүжилт /тодорхой хэмжээгээр байж болно/
 - 9.1.6. Олон улсын байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон тесэл, үйлчилгээний орлого;
 - 9.1.7. Технологийн болон зөвлөх үйлчилгээ, инкубаторын үйл ажиллагаанаас олсон орлого;
 - 9.1.8. Хууль болон энэ дүрмээр зөвшөөрсөн аж ахуйн үйл ажиллагааны орлого;
 - 9.1.9. Хандивлагчдын хандив, тусламж;
- 9.2. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:
 - 9.2.1. Баланс;
 - 9.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;
 - 9.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан;
 - 9.2.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
 - 9.2.5. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал;
 - 9.2.6. Нэмэлт тайлбар;
 - 9.2.7. Санхүүгийн тайлангийн тодруулга;
 - 9.2.8. Бусад.
 - 9.3. Үйлдвэрийн газар нь тухайн жилийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтэц, хөрөнгө санхүүгийн зарцуулалтын талаар тайлан боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.
 - 9.4. Үйл ажиллагааны тайланд доорх зүйлийг тусгасан байна:
 - 9.4.1. Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан технологи, зөвлөх үйлчилгээ, үндсэн үйл ажиллагааны танилцуулга, үйл ажиллагааны үр дүн, түүний өөрчлөлт;
 - 9.4.2. Үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажилтанд олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ;
 - 9.4.3. Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.

Арав. Үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

- 10.1. Үйлдвэрийн газар нь дараах бичиг баримтыг хадгална:
 - 10.1.1. Үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, үйлдвэрийн газрыг байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификат;
 - 10.1.2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж;
 - 10.1.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;
 - 10.1.4. Норм нормативын баримт бичиг, түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар, бусад бичиг баримт;
 - 10.1.5.Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын тушаал, шийдвэр;

- 10.1.6. Бусад ач холбогдол бүхий баримт бичиг.
- 10.2. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх зэрэг ажиллагааг стандартын дагуу гүйцэтгэнэ

Арван нэг. Үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах

- 11.1. Төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах шийдвэрийг Засгийн Газар гаргана.
- 11.2. Засгийн газраас үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулахаар шийдвэрлээгүй тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа тасралтгүй явуулна.


Арван хоёр. Бусад

- 12.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 12.2. Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 12.3. Үйлдвэрийн газрын дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

-----оОо-----

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
дээр дуваар тогтолцоон хөрдүгээр хавсралт

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ТУРШИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НАМСААЛ ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУЛАЛ”



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
23 дугаар тогтоолын туравдугаар хавсралт

**“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
КОРПОРАЦИ” ТӨҮГ-ЫН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

№	Албан тушаал	Нийт ажиллагсад
1	Захирал	1
2	Захиргаа удирдлагын хэлтэс	8
	Хэлтсийн дарга	1
	Нягтлан бодогч	1
	Нярав, касс	1
	Дулаан, шугам сүлжээ, засварын инженер	1
	Цахилгаанчин	1
	Жолооч	1
	Үйлчлэгч	2
3	Шинжлэх ухаан, технологи-инновацийн төв	7
	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	1
	Материал, технологи, инноваци хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан	4
	Сургалт, мэдээлэл хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан	1
	Оюуны өмч, патент, номын сан, стандарт хариуцсан ажилтан	1
4	Инкубаци, бизнес үйлчилгээний төв	4
	Төвийн дарга	1
	Технологи дамжуулалт, гарaanы бизнес хариуцсан ажилтан	1
	Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан ажилтан	1
	Технологи дамжуулалт, гарaanы бизнес хариуцсан ажилтан	1
	Инкубаци, зөвлөх үйлчилгээ хариуцсан ажилтан	1
IV	Арьс ширний төв лаборатори	5
	Лабораторийн эрхлэгч	1
	Химич	1
	Шинжээч	2
	Техникийн тоног төхөөрөмж хариуцсан ажилтан	1
	Нийт ажиллагсад	25